



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 19 нэрийн, нийт 11,530,490.00 (арван нэгэн сая таван зуун гучин мянга дөрвөн зуун ер) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзулд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000953

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн
33-7.3 дугаар тогтоолын хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Дарга ширээ	11/30/2016	2	180,000.00	360,000.00	360,000.00	-
2	Дарга утгар ширээ	11/30/2016	2	780,000.00	1,560,000.00	1,560,000.00	-
3	Шүүгээ номын	2/18/2014	1	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	-
4	Цаас тогтоогч	2/18/2014	1	270,000.00	270,000.00	270,000.00	-
5	Ширээ хурал	2/18/2014	1	480,000.00	480,000.00	480,000.00	-
6	Шүүгээ номын өндөр	4/3/2014	1	650,000.00	650,000.00	650,000.00	-
7	Шар ширээ бичиг	4/30/2014	1	560,000.00	560,000.00	560,000.00	-
8	Шар ширээ бичиг	12/31/2014	1	499,500.00	499,500.00	499,500.00	-
9	Теринижёр /дасгалын төхөөрөмж/	1/10/2014	1	1,360,000.00	1,360,000.00	1,360,000.00	-
10	Шкаф хувцасны /шар/	6/30/2015	1	382,000.00	382,000.00	382,000.00	-
11	Хурлын сандал хар	11/30/2016	6	130,000.00	780,000.00	780,000.00	-

12	Гүйдэг хаалгатай шүүгээ /шар/	11/30/2016	2	185,000.00	370,000.00	370,000.00	-
13	Принтер samsung 2070	4/27/2020	1	349,200.00	349,200.00	349,200.00	-
14	Агаар цэвэршүүлэгч /БСБ/	4/27/2020	1	485,000.00	485,000.00	485,000.00	-
15	Агаар цэвэршүүлэгч ion sharp	4/23/2020	1	330,000.00	330,000.00	330,000.00	-
16	Кофе чанагч /philips/	4/9/2020	1	99,900.00	99,900.00	99,900.00	-
17	Ус буцалгагч /sonifer/	4/9/2020	1	49,900.00	49,900.00	49,900.00	-
18	Агааржуулагч /Keruilai/	4/23/2020	1	395,000.00	395,000.00	395,000.00	-
19	Проектор /Optoma/	4/27/2020	1	1,349,990.00	1,349,990.00	1,349,990.00	-
Нийт дүн			27		11,530,490.00	11,530,490.00	
					(арван нэгэн сая таван зуун гучин мянга дөрвөн зуун ер)	(арван нэгэн сая таван зуун гучин мянга дөрвөн зуун ер)	